



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/195

Номгон


Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй
боловсон хүчнээр хангах, удирдах болон
гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх
хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 м, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2, Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 102 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчинг орон нутагт бэлтгэхээр Түүх нийгмийн Тэнгэр дээд сургуультай гэрээ байгуулж, хамтран ажилласугай.

2.Сургалтын үйл ажиллагаанд зарцуулах 2,000.000 (Хоёр сая) төгрөгийг аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3. Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Архивын тасаг (В.Эрдэнэчимэг), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав) нарт тус тус үүрэг болгосугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

1210489